



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 01

Эрдэнэт

Үйл ажиллагааны хөтөлбөр,  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 "д" заалт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухай аймгийн Засаг дарга Д.Батлутын тавьсан илтгэлийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит III хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Бүрэн эрхийн хугацаанд аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, хэрэгжилтийн явц үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /Д. Батлут/-д даалгасугай.

ДАРГА



П. ПҮРЭВЛХАГВА